

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба



## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

АУДИТЫН НЭР: ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

УДИРДАМЖИЙН КОД: №02

| 2024

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА:**

СЭЛЭНГЭ АЙМАГ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

**АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА:**

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ 1, ТТЗ-ИЙН 17, ТУСГАЙ САН 35 *ЮНХС-ИЙН 18*, *ХХС-ИЙН 17I*, ТШЗ-ИЙН 51, ОНӨААТҮГ-ЫН 23 НИЙТ 127 БАЙГУУЛЛАГА, НЭГЖ ХАМРАГДЛАА.

**АУДИТЫН ТӨРӨЛ:** НИЙЦЛИЙН АУДИТ

**АУДИТЫН ХУГАЦАА:** 2024.04.01-2024.06.30

**ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ДАРГА:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АХЛАХ ДОТООД АУДИТОР,  
СХШУБ: Т.МӨНХЗУЛ

**АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮД:**

ДОТООД АУДИТОР Х.БАТБААТАР

ДОТООД АУДИТОР Г.ДОРЖДЭРЭМ

**Тайлан бэлтгэсэн:**

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба

Дотоод ахлах аудитор СХШУБ  
Т.Мөнхзул

Дотоод аудитор  
Х.Батбаатар

Дотоод аудитор  
Г.Дорждэрэм

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал  
Sankhuu\_audit\_Se@yahoo.com мэйл хаягаар харилцана уу.

ХАЯГ: Сүхбаатар сум Орхон 6 дугаар баг, Нутгийн удирдлагын II ордон, 1 давхар

2024 оны 04 дүгээр сар

**АГУУЛГА**

**1. ТАНИЛЦУУЛГА**

**2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ**

2.1 Аудитын зорилго

2.2 Аудитын цар хүрээ, хязгаарлалт

2.3 Аудитын арга зүй

**3. АУДИТЫН ҮР ДҮН**

3.1 Илэрсэн асуудлууд

**5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

## 1. ТАНИЛЦУУЛГА

Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны үйл ажиллагааны 2024 оны дотоод аудит хийх төлөвлөгөөний дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нийт 127 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуй нэгж газар, тусгай сангийн 2024 оны 2 дугаар улирлын шилэн дансны мэдээлэл байршуулалтын үр дүнд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг үндэслэн дотоод аудит хийж дүгнэлт өгөх, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж гүйцэтгэлээ.

Тухайн хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 127 байгууллага нэгжийн шилэн дансны цахим цэсэд 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 10,903 мэдээллийг жил, улирал, сар, тухай бүр гэсэн хугацаанд байршуулахаар хуульчилж өгсөн тул уг тоон мэдээлэл бүрэн, үнэн зөв мэдээлэгдсэн байх шаардлагатай.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1 Аудитын зорилго:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээллээ байршуулж төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан эсэхэд дүгнэлт хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилготой.

### 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-3.2 дахь хэсэгт заасан хуулийн этгээд, төрийн байгууллагууд хуульд заасан мэдээллийг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1-д “Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана” гэж заасны дагуу 2024 оны 2 дугаар улирлын байдлаар шилэн дансны нэгдсэн системд мэдээлсэн байдалд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 127 байгууллагад дотоод аудит хийж гүйцэтгэлээ

### 2.3 Аудитын арга, зүй

Аудитыг гүйцэтгэхэд ДАМПОУС 1100, 2200-2450 дугаар стандарт, “Улсын салбарын байгууллагад дотоод аудит хийх аргачлал”-ын баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуй нэгжийн шилэн дансны цахим хуудаст байрлуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийн, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт гаргалаа.

## 2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль,
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам.

## 2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

Дотоод аудитыг 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс 2024 оны 0 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч) Т.Мөнхзул хянан удирдаж, дотоод аудитор Х.Батбаатар, Г.Дорждэрэм нар аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлж гүйцэтгэв.

### ГУРАВ: АУДИТЫН ҮР ДҮН

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах Төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, харьяа 17 төсвийн төвлөрүүлэн захирагч, 51 төсвийн байгууллага, 23 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 35 тусгай сан, нийт **127** байгууллагыг хамруулан, аудитыг гүйцэтгэсэн.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2024 оны 2 дугаар улирлын шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн аудитаар нийт **10,903** мэдээлэл байршуулахаас **9,351** мэдээлэл байршуулж **1,545** мэдээллийг огт байршуулаагүй, **212** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, **9** мэдээллийн цэсийг сонгож нээгээгүйгээс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн дундаж **83.7** хувьтай тайлагнагдсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны 2 дугаар улирлын шилэн дансны мэдээлэл байршуулалтын үр дүнг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

## Хүснэгт 1.

№	Байгууллагын нэрс	Мэдээлэл байршуулах байгууллагын тоо	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон мэдээллийн тоо	Мэдээлээгүй тоо	Нийт хэрэгжилтийн хувь
1	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	1	78	74	65	9	4	83.3
2	Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар	1	81	68	68	3	13	84.0
3	Сэлэнгэ аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	1	81				81	0.0
4	Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	87	87	84	3		96.6
5	Сэлэнгэ аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	87	87	85	2		97.7
6	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	1	87	87	86	1		98.9
7	Орон нутгийн өмчийн газар	1	87	87	87			100.0
8	Алтанбулаг сумын дүн	5	426	426	416	10		97.7
9	Баруунбүрэн сумын дүн	5	426	262	253	9	164	61.5
10	Баянгол сумын дүн	5	432	405	389	15	27	93.8
11	Ерөө сумын дүн	6	507	507	495	12		97.6
12	Жавхлант сумын дүн	5	426	426	426			100.0
13	Зүүнбүрэн сумын дүн	5	426	420	407	13	6	95.5
14	Мандал сумын дүн	7	600	438	436	2	162	72.7
15	Орхон сумын дүн	5	426	332	316	12	94	74.2
16	Орхонтуул сумын дүн	6	513	399	378	21	114	73.7
17	Сайхан сумын дүн	7	600	574	562	6	26	93.7
18	Сант сумын дүн	5	432	299	289	10	133	66.9
19	Сүхбаатар сумын дүн	5	426	339	334	5	87	78.4
20	Түшиг сумын дүн	5	426	253	243	10	173	57.0
21	Хушаат сумын дүн	5	442	442	427	15		96.6
22	Хүдэр сумын дүн	5	420	369	360	9	51	85.7
23	Цагааннуур сумын дүн	5	421	421	421			100.0
24	Шаамар сумын дүн	6	507	330	326	4	177	64.3
25	Ойн ангийн дүн	5	435	435	425	10		97.7
26	ОНӨААТҮГ-ын дүн	23	2024	1784	1754	30	233	86.7
	<b>Нийт дүн</b>	<b>127</b>	<b>10903</b>	<b>9351</b>	<b>9131</b>	<b>212</b>	<b>1545</b>	<b>83.7</b>

<b>Илэрсэн асуудал 1</b>	ТТЗ-ийн түвшинд шилэн дансны мэдээллийн хугацаа хоцроож мэдээлсэн, болон ОНХС, ХХС-ийн шилэн дансны цэсийг нээж бүртгүүлээгүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал:	

1. Алтанбулаг сумын хэмжээнд 5 байгууллага 426 мэдээлэл байршуулахаас 426 мэдээлэл байршуулж 10 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Нийт мэдээлэл байршуулалтын хувь 97.7%-тай
2. Баруунбүрэн сумын хэмжээнд 5 байгууллага 426 мэдээлэл байршуулахаас 262 мэдээлэл байршуулж 164 мэдээлэл огт байршуулаагүй, 9 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсан, 162 мэдээллийн цэсийг нээж ил тод болгож байршуулаагүй. Мэдээлэл байршуулалтын хувь 61.5%-тай
3. Баянгол сумын хэмжээнд 5 байгууллага 432 мэдээлэл байршуулахаас 405 мэдээлэл байршуулж 27 мэдээлэл огт байршуулаагүй, 15 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Мэдээлэл байршуулалтын хувь 93.8%-тай
4. Ерөө сумын хэмжээнд 6 байгууллага 507 мэдээлэл байршуулахаас 507 мэдээлэл байршуулж 12 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Мэдээлэл байршуулалтын хувь 97.6%-тай
5. Жавхлант сумын хэмжээнд 5 байгууллага 426 мэдээлэл байршуулахаас 426 мэдээлэл байршуулж мэдээлэл байршуулалтын хувь 100.0%-тай
6. Зүүнбүрэн сумын хэмжээнд 5 байгууллага 426 мэдээлэл байршуулахаас 420 мэдээлэл байршуулж 6 мэдээлэл огт байршуулаагүй, 13 мэдээллийн хуулийн хугацаа хоцроож байршуулсан. Нийт мэдээлэл байршуулалтын хувь 95.5%-тай
7. Мандал сумын хэмжээнд 7 байгууллага 600 мэдээлэл байршуулахаас 438 мэдээлэл байршуулж 162 мэдээлэл огт байршуулаагүй, 2 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Огт байршуулаагүй 162 мэдээллийн цэсийг нээж ил тод болгоогүй. Мэдээлэл байршуулалтын хувь 72.7%-тай
8. Орхон сумын хэмжээнд 5 байгууллага 426 мэдээлэл байршуулахаас 332 мэдээлэл байршуулж, 94 мэдээлэл огт байршуулаагүй, 12 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан. Мэдээлэл байршуулалтын хувь 74.2%-тай
9. Орхонтуул сумын хэмжээнд 6 байгууллага 513 мэдээлэл байршуулахаас 399 мэдээлэл байршуулж, 114 мэдээлэл огт байршуулаагүй, 21 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 73.7%-тай
10. Сайхан сумын хэмжээнд 7 байгууллага 600 мэдээлэл байршуулахаас 574 мэдээлэл байршуулж 26 мэдээлэл огт байршуулаагүй, 6 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан, 81 мэдээллийн цэсийг нээж ил тод болгож байршуулаагүй мэдээлэл байршуулалтын хувь 93.7%-тай
11. Сант сумын хэмжээнд 5 байгууллага 432 мэдээлэл байршуулахаас 299 мэдээлэл байршуулж 133 мэдээлэл огт байршуулаагүй, 10 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, 81 мэдээллийн цэсийг нээж ил тод болгож байршуулаагүй мэдээлэл байршуулалтын хувь 66.9%-тай
12. Сүхбаатар сумын хэмжээнд 5 байгууллага 426 мэдээлэл байршуулахаас 339 мэдээлэл байршуулж 87 мэдээлэл огт байршуулаагүй, 5 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан, 81 мэдээллийн цэсийг нээж ил тод болгож байршуулаагүй мэдээлэл байршуулалтын хувь 78.4%-тай
13. Түшиг сумын хэмжээнд 5 байгууллага 426 мэдээлэл байршуулахаас 253 мэдээлэл байршуулж 173 мэдээлэл огт байршуулаагүй, 10 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан, 162 мэдээллийн цэсийг нээж ил тод болгож байршуулаагүй мэдээлэл байршуулалтын хувь 57.0%-тай
14. Хушаат сумын хэмжээнд 5 байгууллага 442 мэдээлэл байршуулахаас 442 мэдээлэл, 15 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 96.6%-тай
15. Хүдэр сумын хэмжээнд 5 байгууллага 420 мэдээлэл байршуулахаас 369 мэдээлэл байршуулж 51 мэдээлэл огт байршуулаагүй, 9 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 85.7%-тай
16. Цагааннуур сумын хэмжээнд 5 байгууллага 421 мэдээлэл байршуулахаас 421 мэдээлэл байршуулж мэдээлэл байршуулалтын хувь 100.0%-тай
17. Шаамар сумын хэмжээнд 6 байгууллага 507 мэдээлэл байршуулахаас 330 мэдээлэл байршуулж 177 мэдээлэл огт байршуулаагүй, 4 мэдээллийн хуулийн хугацааг хоцроож

байршуулсан, 162 мэдээллийн цэсийг нээж ил тод болгож байршуулаагүй мэдээлэл байршуулалтын хувь 64.3%-тай
Байх ёстой шаардлага /шалгуур/: 2024 оны 2-р улирлын байдлаар ТЕЗ, ТТЗ, ТШЗ, Тусгай сан, ОНӨААТҮГ-ын нийт 10,845 мэдээллийг сар, улирал, тухайн үед гэсэн хугацаанд ангиллаар байршуулахаар хуульчилж өгсөн тул уг тоон мэдээлэл бүрэн, үнэн зөв мэдээлэгдсэн байх шаардлагатай
Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны шинэ цахим хуудсанд шинээр бүртгэл үүсгэж бүртгүүлээгүй, бүртгэл үүсгэсэн боловч мэдээллийг дутуу оруулсан, мэдээлэл оруулах албан тушаалтан бүрэн гүйцэт сонгож баталгаажуулаагүй, мэдээлэл байршуулалтын хуулийн хугацааг хэтрүүлсэн, нийтэд ил тод болгоогүй
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: <ul style="list-style-type: none"> <li>- Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй</li> <li>- Шилэн дансны мэдээлэл байршуулалтын хугацаа хоцрох,</li> <li>- Аймгийн шилэн дансны мэдээлэл байршуулалтын хувийг бууруулах, сөргөөр нөлөөлөх</li> </ul>
Зөвлөмж: Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулах.

2. Ой ангийн 5 газрууд нь тухайн хугацаанд 435 мэдээлэл байршуулахаас 435 мэдээлэл байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, нийт мэдээлэл байршуулалт 97.7%-тай дүгнэгдэж байна.

3. ОНХС, ХХС-ийн 35 газрууд нь тухай хугацаанд 2,864 мэдээлэл байршуулахаас 1,778 мэдээлэл байршуулж 1, 086 мэдээллийг огт байршуулаагүй, 31 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, нийт мэдээлэл байршуулалт 62.1%-тай дүгнэгдэж байна.

4. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд нь тухайн хугацаанд 2,024 мэдээлэл байршуулахаас 1784 мэдээлэл байршуулж 233 мэдээллийг огт байршуулаагүй, 30 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 88 мэдээллийн цэсийг нээж ил тод болгож байршуулаагүй мэдээлэл байршуулалт 86.7%-тай дүгнэгдэж байна.

<b>Илэрсэн асуудал 3</b>	Шилэн дансны цахим хуудсанд хангалтгүй мэдээлэл байршуулсан ОНӨААТҮГ-ууд
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал:	
<ol style="list-style-type: none"> <li>1. Хушаат дуут хад ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 88 мэдээлэл байршуулж, мэдээлэл байршуулалтын хувь 100.0%-тай</li> <li>2. Илдэн бүрэн ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 57 мэдээлэл байршуулж 31 мэдээлэл огт байршуулаагүй, 2 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 62.5%-тай</li> <li>3. Мандал Энерго ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 75 мэдээлэл байршуулж, 13 мэдээлэл огт байршуулаагүй, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 84.1%-тай</li> <li>4. Тохилог Хараа ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 75 мэдээлэл байршуулж, 13 мэдээлэл огт байршуулаагүй, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 84.1%-тай</li> </ol>	

5. Өргөн Сэлэнгэ ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 88 мэдээлэл байршуулж, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 98.9%-тай
6. Энхмэнд сувилал ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 86 мэдээлэл байршуулж, 2 мэдээлэл огт байршуулаагүй, 3 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 94.3%-тай
7. Цэнгэг-Ус ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 71 мэдээлэл байршуулж, 17 мэдээлэл огт байршуулаагүй, 6 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 73.9%-тай
8. Хүдэр тохижилт ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 88 мэдээлэл байршуулж, 2 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 97.7%-тай
9. Туулын хишиг ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 81 мэдээлэл байршуулж, 7 мэдээлэл огт байршуулаагүй, 3 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 93.5%-тай
10. Цагаан-Эрэг тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 82 мэдээлэл байршуулж, 6 мэдээлэл огт байршуулаагүй, 3 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 89.8%-тай
11. Мандал шинэ агротехник ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 88 мэдээлэл байршуулсан мэдээлэл байршуулалтын хувь 100.0%-тай
12. Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 88 мэдээлэл байршуулж, 3 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 96.6%-тай
13. Хүдэр ой анги ОНӨААТҮГ нь 88 мэдээлэл байршуулахаас 88 мэдээлэл байршуулж, 2 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 97.7%-тай
14. Баянгол сумын Баянгол сувилал ОНӨААТҮГ 88 мэдээлэл байршуулахаас 88 мэдээлэл байршуулж, 2 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 97.7%-тай
15. Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ 82 мэдээлэл байршуулахаас 82 мэдээлэл байршуулж, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 97.8%-тай
16. Цагааннуур тохижилт ОНӨААТҮГ 88 мэдээлэл байршуулахаас 88 мэдээлэл байршуулж, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 98.9%-тай
17. Тохилог хараа ОНӨААТҮГ 88 мэдээлэл байршуулахаас 75 мэдээлэл байршуулж, 13 мэдээлэл огт байршуулаагүй, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 84.1%-тай.
18. Мандал хишиг хайрхан ОНӨААТҮГ 88 мэдээлэл байршуулахаас 88 мэдээлэл огт байршуулаагүй мэдээлэл байршуулалтын хувь 0.0%-тай.
19. Гавшгай Ус ОНӨААТҮГ 88 мэдээлэл байршуулахаас 55 мэдээлэл байршуулж, 33 мэдээлэл огт байршуулаагүй, мэдээлэл байршуулалтын хувь 62.5%-тай.
20. Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ 88 мэдээлэл байршуулахаас 75 мэдээлэл байршуулж, 13 мэдээлэл огт байршуулаагүй, 1 мэдээллийг хуулийн хугацааг хоцроож байршуулсан, мэдээлэл байршуулалтын хувь 84.1%-тай.
21. Сэлэнгэ Энерго, Сэлэнгэ үржлийн цөм сүрэг, Сэлэнгэ барилга захиалагч, Мандах зэлтэр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-уудын мэдээлэл байршуулалтын хувь 100.0 хувьтай байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/: Монгол Улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн Газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Шилэн дансны тухай хуульд заасан 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар нь шилэн дансны мэдээллийг тогтмол мэдээлнэ.

Асуудлын үндсэн шалтгаан: Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны шинэ цахим хуудсанд шинээр бүртгэл үүсгэж бүртгүүлээгүй, бүртгэл үүсгэсэн боловч мэдээллийг дутуу оруулсан, мэдээлэл оруулах албан тушаалтан бүрэн гүйцэт сонгож баталгаажуулаагүй, мэдээлэл байршуулалтын хуулийн хугацааг хэтрүүлсэн, нийтэд ил тод болгоогүй
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: <ul style="list-style-type: none"> <li>- Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй</li> <li>- Шилэн дансны мэдээлэл байршуулалтын хугацаа хоцрох,</li> <li>- Аймгийн шилэн дансны мэдээлэл байршуулалтын хувийг бууруулах, сөргөөр нөлөөлөх</li> </ul>
Зөвлөмж: Монгол Улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн Газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Шилэн дансны тухай хуульд заасан 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1.2. төрийн өмчит үйлдвэрийн газар нь шилэн дансны мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасны дагуу шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулах.

#### 4.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас харьяа нийт 127 байгууллага нэгжид “Шилэн дансны тухай” хууль, Загийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд хяналт шалгалтыг гүйцэтгэхэд 2024 оны 2-р улирлын байдлаар 83.7 хувьтай буюу “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үй явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 21-79% нь “нөлөө ихтэй” гэж үзсэн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтын дүгнэлтийг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт 2.

№	Байгууллагын нэрс	Байгууллагын тоо	Нийт хэрэгжилт хувиар	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
1	Сайхан сум	7	93.7	Хангалттай	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ил тод байдлыг ханган ажилласан.
2	Баянгол сум	5	93.8	Хангалттай	
3	Зүүнбүрэн сум	5	95.5	Хангалттай	
4	Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	96.6	Хангалттай	
5	Хушаат сум	5	96.6	Хангалттай	
6	Ерөө сум	6	97.6	Хангалттай	
7	Сэлэнгэ аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	97.7	Хангалттай	

8	Алтанбулаг сум	5	97.7	Хангалттай	
9	Ойн ангийн дүн	5	97.7	Хангалттай	
10	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	1	98.9	Хангалттай	
11	Орон нутгийн өмчийн газар	1	100.0	Хангалттай	
12	Жавхлант сум	5	100.0	Хангалттай	
13	Цагааннуур сум	5	100.0	Хангалттай	
14	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	1	83.3	Сайжруулах шаардлагатай	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ил тод, нээлттэй байх хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны мэдээлэл байршуулалтын сайжруулах шаардлагатай
15	Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар	1	84	Сайжруулах шаардлагатай	
16	Хүдэр сум	5	85.7	Сайжруулах шаардлагатай	
17	ОНӨААТҮГ-ын дүн	23	86.7	Сайжруулах шаардлагатай	
18	Сэлэнгэ аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	1	0	Хангалтгүй	Орон нутгийн төсвийн болон өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулахад төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн.
19	Түшиг сум	5	57.0	Хангалтгүй	
20	Баруунбүрэн сум	5	61.5	Хангалтгүй	
21	Шаамар сум	6	64.3	Хангалтгүй	
22	Сант сум	5	66.9	Хангалтгүй	
23	Мандал сум	7	72.7	Хангалтгүй	
24	Орхонтуул сум	6	73.7	Хангалтгүй	
25	Орхон сум	5	74.2	Хангалтгүй	
26	Сүхбаатар сум	5	78.4	Хангалтгүй	
<b>Нийт дүн</b>		<b>127</b>	<b>83.7</b>		

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “үнэн зөв, бодиттой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-6.5 заасан хугацааг хоцроосон, огт мэдээлээгүй зөрчил илэрсэн байна.

Иймд ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай ОНӨААТҮГ-ын 1, ТТЗ-ийн 12, ТШЗ-ийн 6 эрх бүхий албан тушаалтнуудад Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д “Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах”, Засгийн газрын

2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ.” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага, болон хариуцлага тооцох үндэслэл бүрдэж байгаа тул цаашид төсвийн ил тод байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх ажиллах чиглэлээр энэ шалгалтын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, НЯГТЛАН БОДОГЧ НАРТ ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭХ НЬ

1. Шилэн дансны тухай хуулийн 8.4-т “Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.
2. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” 8.1-д заасан Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнаж байх.
3. Орон нутгийн төсвийн болон өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулахад төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх хуулиар хүлээсэн үүргээ сайжруулах.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:  
ДОТООД АУДИТОР

 Х.БАТБААТАР

БАТАЛГААЖУУЛСАН:  
АХЛАХ ДОТООД АУДИТОР  
СХШУБ



 Т.МӨНХЗУЛ